



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2026 ОНЫ ТАЙЛАН

(2026 оны I улирал)

УЛААНБААТАР ХОТ
2026 он

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2026 ОНЫ I УЛИРЛЫН ТАЙЛАН

2026 оны 04 дүгээр сарын 06

Улаанбаатар хот

НЭГ.БОДЛОГЫН БАРИМТ БИЧГҮҮДЭД ТУСГАГДСАН ЗОРИЛТ,
АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

1.1.“Жуулчдад зориулсан соёлын болон тусгай сонирхлын аялал жуулчлалын арга хэмжээнүүдийг тогтмол зохион байгуулж, аяллын шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох” зорилтын хүрээнд:

1.1.1.“Монголд зочлох жил”-ийн хүрээнд Улаанбаатар хотын аялал жуулчлалыг хөгжүүлэх, жуулчдад зориулсан бүтээгдэхүүн, үйлчилгээг нэмэгдүүлэх зорилгоор 2026 онд зохион байгуулах аялал жуулчлалын арга хэмжээний хуваарийг гарган Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яаманд хүргүүлж, “Монгол Улсад 2026 онд зохион байгуулах аялал жуулчлалын арга хэмжээний нэгдсэн цаглавар”-т нийт 140 /спортын 14, соёл, аялал жуулчлалын 99, /MICE tourism/ буюу олон улсын хурал, зөвлөгөөн, үзэсгэлэн 27/ арга хэмжээ тусгагдсанаас Нийслэлийн Аялал жуулчлалын газраас 16 арга хэмжээ арга хэмжээг хариуцан зохион байгуулахаар төлөвлөөд байна.

Улаанбаатар хотын аялал жуулчлалын газар	Улаанбаатар	2026	UB TOURISM EVENT
2026.01.31-02.01	"УЛААНБААТАР" WINTER FESTIVAL		
2026.02.28-03.01	"УЛААНБААТАР" WINTER WALKING FESTIVAL		
2026.03.07-08	EAGLE FESTIVAL		
2026.03.22	NAURYZ FESTIVAL		
2026.05.08-10	"POWER EXPO" FESTIVAL		
2026.05.31	THE BUDDHA PURNIMA		
2026.06.06-07	"STEPPE WIND" INTERNATIONAL MOTO FESTIVAL		
2026.06.12-14	"TENGER" SHAMAN FESTIVAL		
2026.06.20	"REGGAE" MUSIC FESTIVAL		
2026.06.27-28	CITIZEN'S DAY OF ULAANBAATAR KHUREE TSAM-DANSHIG NAADAM		
2026.07.02-04	"PLAYTIME" INTERNATIONAL MUSIC FESTIVAL		
2026.07.09	"DEELTEI MONGOL" FESTIVAL		
2026.08.06-09	"UB FOOD" FESTIVAL		
2026.08.26-30	"УЛААНБААТАР" WALKING INTERNATIONAL FESTIVAL		
2026.09.05-06	THE "THOUSAND HORSEMEN" FESTIVAL		
2026.09.05-06	"KHIMORI" HORSEBACK ARCHERY FESTIVAL		
2026.09.05-10	"CROSSING BRIDGES 23" INTERNATIONAL PHOTOGRAPHY FESTIVAL		

Нийслэлийн аялал жуулчлалын газар	Улаанбаатар	2026	АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН АРГА ХЭМЖЭЭНИЙ ХУАНЛИ
2026.01.31-02.01	"УЛААНБААТАР" ӨВЛИЙН НААДАМ		
2026.02.28-03.01	"УЛААНБААТАР" ӨВЛИЙН ЯВГАН АЛХАЛТЫН ӨДРҮҮД		
2026.03.07-08	БҮРГЭДИЙН БАЯР		
2026.03.22	НАРНЫ БАЯР /НАУРЫЗЫН БАЯР/		
2026.05.08-10	"ПОВЕР ЭКСПО" АВТО УРАЛДААН		
2026.05.31	БУРХАН БАГШИЙН ИХ ДҮЙЧИН ӨДӨР		
2026.06.06-07	"ТАЛЫН САЛХИ" ОЛОН УЛСЫН МОТО НААДАМ		
2026.06.12-14	"ТЭНГЭР" БӨӨГИЙН НААДАМ		
2026.06.20	"РЭГГИ" ХӨГЖИЙН НААДАМ		
2026.06.27-28	НИЙСЛЭЙН УЛААНБААТАР ХОТЫН ИРГЭДИЙН ӨДӨР "ХҮРЭЭ ЦАМ-ДАНШИГ НААДАМ"		
2026.07.02-04	"ПЛЭЙТАЙМ" ОЛОН УЛСЫН ХӨГЖИЙН НААДАМ		
2026.07.09	"ДЭЭЛТЭЙ МОНГОЛ" НААДАМ		
2026.08.06-09	"УБ ФУТ" ОЛОН УЛСЫН ХООЛНЫ ӨДРҮҮД		
2026.08.26-30	"УЛААНБААТАР" ОЛОН УЛСЫН ЯВГАН АЛХАЛТЫН ӨДРҮҮД		
2026.09.05-06	"МЯНГАН МОРЬТОН" НААДАМ		
2026.09.05-06	"ХИЙМОРЬ" МОРЬТ ХАРВААНЫ ОЛОН УЛСЫН ТЭМЦЭЭН		


МОНГОЛ УЛСАД 2026 ОНД БОЛОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ НЭГДСЭН ХУАНЛИ
УЛИРАЛ

1-р сар	2-р сар	3-р сар
Улаанбаатар хотын аялал жуулчлалын газар	Монголын аялал жуулчлалын газар	Улаанбаатар хотын аялал жуулчлалын газар
2026.01.31-02.01	2026.02.28-03.01	2026.03.07-08
2026.03.22	2026.05.08-10	2026.05.31
2026.06.06-07	2026.06.12-14	2026.06.20
2026.06.27-28	2026.07.02-04	2026.07.09
2026.08.06-09	2026.08.26-30	2026.09.05-06
2026.09.05-06	2026.09.05-10	

МОНГОЛ УЛСАД 2026 ОНД БОЛОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ НЭГДСЭН ХУАНЛИ
УЛИРАЛ

7-р сар	8-р сар	9-р сар
2026.07.02-04	2026.07.09	2026.08.06-09
2026.08.26-30	2026.09.05-06	2026.09.05-06

1.1.2. Улаанбаатар хотын аялал жуулчлалыг хөгжүүлэх, жуулчдад зориулсан бүтээгдэхүүн, үйлчилгээг нэмэгдүүлэх, үндэсний ёс заншил, өв уламжлалаар дамжуулан гадаад, дотоодын жуулчдыг татах зорилгоор төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодтой хамтран "Талын Жавхаа", "Улаанбаатарын өвлийн наадам", "Улаанбаатар өвлийн явган алхалтын фестиваль", "Бүргэдийн баяр", "Наурызын баяр" зэрэг 5 арга хэмжээг тайлант хугацаанд зохион байгуулж гадаад, дотоодын нийт 33,600 гаруй хүн үзэж сонирхсон. Үүнд:



Талын жавхаа




Улаанбаатарын өвлийн наадам



Улаанбаатар өвлийн явган алхалтын фестиваль



Бүргэдийн баяр




Наурыздын баяр

"Талын жавхаа"

1.1.3. Улаанбаатар хотод өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх, иргэд, жуулчдын сонирхолд нийцсэн бүтээгдэхүүн үйлчилгээг нэмэгдүүлэх, адууны өв соёлыг таниулан сурталчлах зорилгоор "Талын жавхаа" арга хэмжээг Монголын адуучдын холбоотой хамтран "Чингис Хааны Хүрээ" аялал жуулчлалын цогцолборт 2026 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр зохион байгууллаа.

"Талын Жавхаа" адуучны тэмцээнд нийслэлийн Багануур, Багахангай, Баянзүрх, Хан-Уул, Сонгинохайрхан, Сүхбаатар дүүргүүд, Архангай, Булган, Дархан-Уул, Дорноговь, Дорнод, Дундговь, Хэнтий, Төв, Орхон, Өвөрхангай, Сүхбаатар, Сэлэнгэ, Увс зэрэг 13 аймгаас нийт 150 адуучин оролцож, уурга, ташуур шүүрэх, эмнэг булгиулах, морь уургалах, бугуйлдах тэмцээн зохион байгуулагдав.

Арга хэмжээний үеэр адуучдын парад, урлагийн тоглолт, Монгол бүжгийн флаш моб үзүүлбэр зохион байгуулагдаж, хамгийн сайхан үндэсний дээл, хувцастай оролцогчийг шалгаруулан мөн Монгол үндэсний ахуй өвөл цагийн адуу маллах соёлтой танилцах болон морь, морин чарга уналга, гар урлалын худалдаа, үйлчилгээг зохион байгуулж, арга хэмжээг гадаад, дотоодын иргэд, жуулчид нийт 3000 гаруй хүн үзэж сонирхсон.






“Улаанбаатарын өвлийн наадам”

1.1.4. Улаанбаатар хотод өвлийн болон тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх, өвлийн улиралд Улаанбаатар хотод ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх, иргэдийн амралт, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, үндэсний тоглоом наадгай болон орчин үеийн экстрим спортыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор 14 дэх удаагийн “Улаанбаатарын өвлийн наадам” арга хэмжээг “Скай резорт” цанын баазад 2026 оны 01 дүгээр сарын 31, 02 дугаар сарын 01-ний өдрүүдэд зохион байгуулав.

“Улаанбаатар өвлийн наадам” арга хэмжээний хүрээнд Мөсөн сурын олон улсын аварга шалгаруулах тэмцээн, Мөсний шагайн улсын аварга шалгаруулах тэмцээн, Параглайдингийн (уулын шүхэр) Улаанбаатар хотын аварга шалгаруулах тэмцээн, Снөүбоардын Улаанбаатар хотын аварга шалгаруулах тэмцээн, Уулын цанын Улаанбаатар хотын аварга шалгаруулах тэмцээн, Кёрлингийн Улаанбаатар хотын аварга шалгаруулах тэмцээн, “Grand tour winter cup 2026” аялал жуулчлалын салбарын оюутнууд дундах буухиа тэмцээн зэрэг 7 төрлийн уралдаан тэмцээнд ОХУ-ын Бүгд найрамдах Буриад улс, Бүгд найрамдах Тува улс, Бүгд найрамдах Халимаг улс, БНХАУ-ын ӨМӨЗО, Шинжаан Уйгур, БНКазахстан Улс, АНУ зэрэг улсаас 46, Монгол Улсын 21 аймаг болон Улаанбаатар хотоос 1500 гаруй хүн оролцлоо.

Арга хэмжээний үеэр иргэд, сонирхогчдын дунд мөсөн хана авиралтын тэмцээн зохион байгуулж, мөн параглайдингийн үзүүлбэр, шувуулахуйн үзүүлбэр танилцуулга, банхар нохдын үзүүлбэр танилцуулга, цана чарганы үйлчилгээ, хоол ундны үйлчилгээ, цаа буга, морь, тэмээ унах үйлчилгээг зохион байгуулж арга хэмжээг гадаад, дотоодын иргэд, жуулчид нийт 10,000 гаруй хүн үзэж сонирхлоо.








“Улаанбаатарын өвлийн явган алхалтын фестиваль”

1.1.5. Улаанбаатар хотод өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх, жуулчны улирлын хугацааг уртасгах зорилгоор Монголын явган алхалтын холбоотой хамтран “Улаанбаатарын өвлийн явган алхалтын фестиваль-2026” арга хэмжээг 2026 оны 03 дугаар сарын 07, 08-ны өдрүүдэд Горхи-тэрэлжийн байгалийн цогцолборт газарт байрлах “Чингис 21” жуулчны баазад зохион байгууллаа.

Фестивальд АНУ, Нидерланд Улс (Голланд), БНЧУ, БНСУ, БНХАУ зэрэг 5 улсаас 50 гаруй алхагч, “Монголын явган алхалтын холбоо”-ны салбар холбоод 21 аймаг, нийслэлийн дүүргүүдийн төлөөлөгчид, явган алхалтын клубүүдийн нийт 600 гаруй алхагчид оролцов.

Арга хэмжээний үеэр олон улсын стандартын дагуу тэмдэг, тэмдэглэгээг бүрэн байршуулж тохижуулсан “Чингис-21” явган алхалтын замын нээлтийн үйл ажиллагааг зохион байгуулж, оролцогчид шинэ маршрутаар 5 км явган алхалт хийж, мөн оролцогчдын дунд мөсөн сурын тэмцээн, олс таталтын тэмцээн зохион байгууллаа.





“Бүргэдийн баяр”

1.1.6. Казах түмний ёс заншил, өв уламжлал, соёлыг сурталчлан таниулах, бүргэдээр ан хийх дахин давтагдашгүй өвөрмөц соёлоор дамжуулан гадаад, дотоодын жуулчдыг татах, өвлийн улиралд Улаанбаатар хотод зорин ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх зорилгоор “Бүргэдийн баяр-2026” арга хэмжээг 2025 оны 03 дугаар сарын 07, 08-ны өдрүүдэд “Чингис хааны хүрээ” аялал жуулчлалын цогцолборт зохион байгууллаа.

“Бүргэдийн баяр-2026” арга хэмжээнд Бүгд Найрамдах Казахстан Улсаас 7, Бүгд Найрамдах Киргиз Улсаас 2, Оросын Холбооны Улсаас 1, Испанийн Хаант Улсаас 3, Унгар улсаас 1, Баян-Өлгий аймгаас 21, Төв аймгаас 1, Сэлэнгэ аймгаас 1 нийт 37 бүргэдчин дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд оролцлоо.

Арга хэмжээний үеэр бүргэдтэй парад, бүргэдүүдийг танилцуулж алдаршуулах арга хэмжээ болон бүргэдчидийн дунд бүргэдээр шьрга (хиймэл ан) бариулах тэмцээн, бүргэдээ хэрхэн сайн сургасан байдлыг шалгаруулах тэмцээн, Казак үндэсний тоглоом көкбар (тулам булаалдах) тэмцээн, зоос шүүрэх тэмцээнүүдийг зохион байгууллаа.

Мөн “Морьтон баатруудын шоу тоглолт”, “Шувуулахуйн үзүүлбэр”, “Шүхрийн үзүүлбэр” болон тойрон бүжиг, цаа буга, тэмээ, морь унах, бүргэд шувуу болон тэмээтэй зураг даруулах болон жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчийн үзэсгэлэн худалдаа, урлагийн тоглолт зэрэг арга хэмжээг зохион байгуулж гадаад, дотоодын иргэд, жуулчид нийт 10,000 гаруй хүн үзэж сонирхов.






“Наурызын баяр”

1.1.7. ЮНЕСКО-ийн хүн төрөлхтний соёлын биет бус өвийн жагсаалтад бүртгэгдсэн “Наурызын баяр”-ын өдрийг тохиолдуулан Казах түмний ёс заншил, өв уламжлал, соёлыг сурталчлан таниулах, түгээн дэлгэрүүлэх, аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгон хөгжүүлэх зорилгоор Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Баян-Өлгий аймгийн нутгийн зөвлөлтэй хамтран “Наурызын баяр-2026” арга хэмжээг 2026 оны 03 дугаар сарын 22-ны өдөр жанжин Д.Сүхбаатарын талбайд зохион байгууллаа.

Арга хэмжээний үеэр Казак хувцастай иргэдийн баярын жагсаал, Казак түмний соёл, ёс заншил, ахуйг таниулсан 6 гэр үзэсгэлэн, Казак түмний уламжлалт хоол, ундаа, жижиг дунд үйлдвэрлэгчдийн үзэсгэлэн худалдаа, Казак хувцастай гэр бүл, хос шалгаруулах тэмцээн, Курэс үндэсний бөхийн тэмцээн, Казакын уламжлалт наадгай Алты бахан /савлуур/ болон урлагийн тоглолт зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгуулж, гадаад, дотоодын иргэд, жуулчид нийт 10,000 гаруй хүн үзэж сонирхсон.




1.2. “Албан бизнес болон өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлж, аялал жуулчлалын улирлын хамраарлыг бууруулах” зорилтын хүрээнд:

1.2.1. Улаанбаатар хотод өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх, жуулчдын урсгалыг нэмэгдүүлэх, өвлийн улиралд бизнесийн байгууллагын үйл ажиллагааг дэмжих, иргэд, жуулчдад хөнгөлөлттэй үнээр үйлчлэх байгууллагуудын тоог нэмэгдүүлэх зорилгоор “UB WINTER SALE” хөнгөлөлтийн аяныг Аялал жуулчлалын мэргэжлийн холбоотой хамтран 3 дахь жилдээ зохион байгууллаа. Аянд Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж байгаа соёл урлаг, аялал жуулчлал, худалдаа, үйлчилгээний 52 аж ахуйн нэгж, байгууллага хамрагдаж бүтээгдэхүүн, үйлчилгээндээ 1+1 урамшуулал болон 5-70 хувь хүртэл хөнгөлөлт, урамшуулалттай үйлчилгээг иргэд, жуулчдад үзүүллээ.




1.2.2. Монгол Улсын Засгийн газрын 2024 оны “Жуулчдын урсгалыг нэмэгдүүлж, дөрвөн улирлын турш жуулчин хүлээн авах зорилтын хүрээнд хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 191 дүгээр тогтоолын хүрээнд Улаанбаатар хотод өвлийн аялал жуулчлалын хөгжүүлэх зорилгоор төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодтой хамтран “Талын Жавхаа”, “Улаанбаатарын өвлийн наадам”, “Улаанбаатар өвлийн явган алхалтын фестиваль”, “Бүргэдийн баяр”, “Наурызын баяр” зэрэг 5 арга хэмжээг зохион байгууллаа.



1.3. “Худалдаа, үйлчилгээ, аялал жуулчлалын зориулалт бүхий төрөлжсөн явуулын үйлчилгээг бий болгож, жижиг дунд, бизнес эрхлэгчдийг дэмжин ажиллах” зорилтын хүрээнд:

1.3.1. Нийслэлийн Засаг даргын 2026 оны А/01 дүгээр захирамжаар 2026 оныг “Бизнес эрхлэгчдийг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан гадаад, дотоодын иргэд, жуулчдад зориулан зохион байгуулсан “Талын Жавхаа”, “Улаанбаатарын өвлийн наадам”, “Бүргэдийн баяр”, “Наурызын баяр” зэрэг 4 арга хэмжээний үеэр 58 жижиг, дунд, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн худалдаа, үйлчилгээг гаргаж үйл ажиллагааг нь дэмжин ажилласан.



1.3.2. Аялал жуулчлалын салбар, үндэсний үйлдвэрлэгчид болон жижиг, дунд бизнес эрхлэгчдийн түншлэл, хамтын ажиллагааг дэмжих зорилгоор Эдийн засаг хөгжлийн яам, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Жижиг, дунд үйлдвэрийн газар, Монголын Аялал жуулчлалын холбоотой хамтран “FEEL MONGOLIA-2026” арга хэмжээг 03 дугаар сарын 27, 28-ны өдрүүдэд зохион байгууллаа.


“FEEL MONGOLIA-2026” арга хэмжээнд үндэсний үйлдвэрлэгчид, үйлчилгээний бизнес эрхлэгчид, соёлын бүтээлч үйлдвэрлэл, эвент арга хэмжээ зохион байгуулагч байгууллагууд, ханган нийлүүлэгчид, зочид буудал, тур оператор зэрэг 150 гаруй аж ахуйн нэгж байгууллага, бизнес эрхлэгчид оролцон үйл ажиллагаагаа сурталчлан танилцууллаа.






1.4. “Улаанбаатар хотын аялал жуулчлалын сурталчилгаанд дэвшилтэд технологийг нэвтрүүлж, контент бэлтгэн, гадаад дотоодод түгээн сурталчлах” зорилтын хүрээнд:

1.4.1. “Талын Жавхаа”, “Улаанбаатарын өвлийн наадам”, “Улаанбаатар өвлийн явган алхалтын фестиваль”, “Бүргэдийн баяр”, “Наурызын баяр” зэрэг 5 арга хэмжээнүүдтэй холбоотой 9 видео танилцуулга, 15 сурталчилгааны рийл хийж байгууллагын www.tourism.ub.gov.mn www.visitulaanbaatar.net цахим хуудас болон газрын facebook, instagram, youtube сувгуудаар цахим сүлжээнд байршуулж олон нийтийн сүлжээгээр сурталчилсан.






1.4.2. Нийслэл Улаанбаатар хотыг гадаадад сурталчлах, жуулчдыг хэрэгцээт мэдээ мэдээллээр хангах, олон улсын үзэсгэлэн, арга хэмжээний үеэр ашиглах зорилгоор Улаанбаатар сэтгүүл 9000 ширхэг (Англи, Герман, Орос хэл дээр), Улаанбаатар хотын хөтөч ном (Guide book) 2500 ширхэг нийт 11,500 ширхэг сурталчилгааны материал эхийг бэлтгэн хэвлэлтэд шилжүүлээд байна.



1.5. “Улаанбаатар хотыг олон улсад сурталчлах чиглэлээр гадаад хамтын ажиллагааг эрчимжүүлэх” зорилтын хүрээнд:

“ITB Berlin” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн


1.5.1. “Монголд зочлох жил”-ийн хүрээнд Монгол Улс, Улаанбаатар хотыг гадаадад сурталчлах, Европын орнуудаас ирэх жуулчдын урсгалыг нэмэгдүүлэх зорилгоор ХБНГУ-ын Берлин хотноо 2026 оны 03 дугаар сарын 03-05-ны өдрүүдэд зохион байгуулагдсан 60 дахь удаагийн “ITB Berlin” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам, Аялал жуулчлалын мэргэжлийн холбооны Европын зах зээлийн салбар холбооны 9 тур оператор компанитай хамтран оролцож “Go Mongolia” үндэсний брэндийн хүрээнд Улаанбаатар хотыг сурталчилсан.



1.6. “Гадаад, дотоод хэвлэл мэдээллийн байгууллагууд, дэлхийд алдартай аялагч нөлөөлөгчдийг урин Улаанбаатар хотын аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг сурталчлах” зорилтын хүрээнд:

1.6.1. Улаанбаатар хотын аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ, жуулчдад зориулан зохион байгуулсан эвент арга хэмжээнүүдийн талаар МҮОНРТ, UBS, TV5, Eagle, C1, SBN, TV8 Монгол ТВ зэрэг 10 гаруй телевиз, News.mn, Gogo.mn, Zarig.mn, Eguur.mn,

lcom.mn зэрэг 25 сайт, Өдрийн сонин, Өнөөдөр, Зууны мэдээ, Монголын мэдээ зэрэг 8 сонин нийт хэвлэл мэдээллийн 40 гаруй байгууллагаар 10 гаруй удаагийн ярилцлага, нэвтрүүлэг, 80 гаруй мэдээ, мэдээллийг хэвлэл мэдээллийн байгууллагуудаар түгээж, үйл ажиллагаагаа сурталчлан ажилласан.



1.6.2. Байгууллагын цахим хуудас www.tourism.ub.gov.mn www.visitulaanbaatar.net болон газрын facebook, instagram, youtube цахим сүлжээнд давхардсан тоогоор 463 мэдээ мэдээлэл, фото зураг, дүрс бичлэг оруулж 2,755,390 хандалт авч үйл ажиллагаагаа олон нийтэд нээлттэй хүргэж ажилласан. Тухайлбал:


www.tourism.ub.gov.mn цахим хуудсанд 44 мэдээ, мэдээлэл оруулж, хандалтын тоо 4120,

www.visit-ulaanbaatar.com цахим хуудсанд 21 мэдээ мэдээлэл, фото зураг, дүрс бичлэг оруулж хандалтын тоо 101,557

<https://www.facebook.com/UlaanbaatarTourism> цахим хуудсанд 378 мэдээ мэдээлэл, фото зураг, дүрс бичлэг оруулж дагагчдын тоо 38,791 хандалтын тоо 2,174,150

<https://www.instagram.com/visit.ulaanbaatar/> цахим хуудсанд 11 фото зураг, дүрс бичлэг оруулж дагагчдын тоо 433, хандалтын тоо 474,163

<https://www.youtube.com/channel/UCjnuixwnzpDZzieEnhXfPFA> цахим хуудсанд 9 дүрс бичлэг оруулж дагагчдын тоо 533, хандалтын тоо 1400 байна.



ХОЁР.ДҮРМЭЭР ХҮЛЭЭСЭН ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

2.1.Аялал жуулчлалын болон жуулчны үйлчилгээний байгууллагуудыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, хамтарч ажиллах;

2.1.1. Төр, хувийн хэвшил, салбар дундын хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам болон Аялал Жуулчлалын Мэргэжлийн Холбоо (Mongolia Tourism Organization)-той хамтран “Tourism Week-2026” үндэсний чуулганыг 2026 оны 03 дугаар сарын 9-15-ны өдрүүдэд Улаанбаатар зочид буудалд зохион байгууллаа.

Чуулганд Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Ч.Ундрэм, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн Дэд сайд Б.Мөнхтамир, Аялал Жуулчлалын Мэргэжлийн Холбооны Ерөнхийлөгч Т.Баттулга, МХАУТ-ын Ерөнхийлөгч Б.Лхагважав нар болон аялал жуулчлалын салбарын 800 гаруй төлөөлөгч

оролцож “Аялал жуулчлалын үндэсний чуулган”, “Аялал жуулчлалын академи”, “Салбар хуралдаанууд”, “Оюутан, залуучуудын өдөр-Ажлын байрын өдөрлөг”, “Аялал жуулчлалын бизнес & хамтын ажиллагааны өдөр” зэрэг үндсэн бүлгүүдийн хүрээнд арга хэмжээнүүдийг зохион байгууллаа.

"Tourism week-2026" үндэсний чуулган салбарын бодлого, хөгжил, тогтвортой аялал жуулчлал, дижитал шилжилт, MICE аялал жуулчлал, COP17 олон улсын хурлыг угтсан байгальд ээлтэй санаачилгууд, дижитал шийдлүүдийг нэвтрүүлэх, салбарын хүний нөөцийг бэхжүүлэх, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг өргөжүүлэх нь зэрэг сэдвүүдээр 72 илтгэгч илтгэл тавьж хэлэлцүүлсэн бөгөөд тус газрын Бодлогын хэрэгжилтийн хэлтсийн дарга С.Туул Улаанбаатар хотод 2026 онд зохион байгуулагдах эвент арга хэмжээний талаар оролцогчдод танилцууллаа.




2.1.2. Нийслэлд худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжүүд болон төрийн байгууллагуудын хариуцлага, хамтын ажиллагаа, хяналтыг сайжруулах нэгдсэн мэдээллийн систем “Онлайн бизнес төв”-ийн “Үйлчилгээ эрхлэх бүртгэл” цэсэд аялал жуулчлалын байр сууцны үйлчилгээ эрхлэгч иргэн, хуулийн этгээдээс зочид буудал, дэн буудал, амралтын газар, жуулчны баазын үйлчилгээ эрхлэхээр нийт 109 хүсэлтийг тайлант хугацаанд ирүүлсэн. Үүнээс зөвшөөрсөн 56, буцаагдсан 33, татгалзсан 3, судлагдаж байгаа 10, хариуцсан дүүрэгт шилжүүлсэн 6, төлөвтэй байна.

2.2. Нийслэлийн хөгжлийн бодлогод нийцүүлэн Улаанбаатар хотын аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр гадаад, дотоодын байгууллагуудтай хамтарч ажиллах;

2.2.1. Налайх дүүргийн нутаг дэвсгэр байрлах “Жуулчин төгөл”-ийн тохижилтын ажлыг “Цайны замын олон улсын холбоо”-ны гишүүн БНХАУ-ын Өвөр Монголын Өөртөө Засах Орны санхүүжилтээр хэрэгжүүлэхээр тохирсны дагуу төслийн техник, эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ), зураг төслийн баримт бичгүүдийг боловсруулан холбогдох байгууллагуудаар хянуулахаар хүргүүлээд байна.

2.2.2. Аялал жуулчлалын байгууллагуудын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, салбарын хүний нөөцийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх асуудлаар 2026 оны 02 дугаар сарын 05-ны өдөр аялал жуулчлалын салбарын төлөөллүүдтэй, Шашин, соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэх, жуулчдад зориулсан бүтээгдэхүүн, үйлчилгээг нэмэгдүүлэх асуудлаар 2026 оны 02 дугаар сарын 11-ний өдөр Гандантэгчинлэн хийдийн төлөөлөлтэй, Улаанбаатар хотын аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг гадаадын хэвлэл, мэдээллийн байгууллагаар сурталчлах ажлын талаар 2026 оны 02 дугаар сарын 11-ний өдөр “Aist global” телевиз, ӨМӨЗО-ны Радио телевизийн улсын хорооны Монгол дахь Төлөөлөгчийн газрын төлөөлөгчидтэй, Улаанбаатар хотын аялал жуулчлалын бүтээгдэхүүн, түүх соёлын дурсгалт газруудын мэдээллийг агуулсан зургийг хийлгэх, www.visit-ulaanbaatar.com цахим хуудсанд гадаад хэлний цэс оруулах асуудлаар “Гэрэгэ турист паспорт” ХХК-ын төлөөлөлтэй тус тус уулзалт зохион байгууллаа.



2.3. Аялал жуулчлалын салбарын хөгжлийн чиг хандлага, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулах;

2.3.1. Аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагуудын чанар, хүртээмжийг сайжруулах, салбарын хүний нөөцийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Нийслэлийн татварын газартай хамтран “Аялал жуулчлалын салбар дахь татвар, даатгал, байгууллагын менежмент, үнэ бодолт” сэдэвт сургалтыг 2026 оны 02 дугаар сарын 10-ны өдөр зохион байгууллаа.

Сургалтыг “Аялал жуулчлалын салбар дахь татварын орчин, татварын тухай шинэчилсэн хууль, татварын хөнгөлөлт, чөлөөлөлт”, “Нийгмийн даатгалын багц хуулиудын тухай ойлголт, зохицуулалт, ажил олгогч, даатгуулагчийн эрх, үүрэг түгээмэл гардаг алдаа, анхаарах асуудлууд”, “Байгууллагын менежмент, үнэ бодолт”, “Аялал жуулчлалын салбарт мөрдөгдөж буй стандартууд” сэдвүүдийн хүрээнд зохион байгуулж сургалтад бизнес эрхлэгч, аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөл нийт 72 хүн хамрагдлаа.

**“АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАР ДАХЬ
ТАТВАР-ДААТГАЛ-
ХАРИЛЦААНЫ МЕНЕЖМЕНТ- ДИПЛОМАТ
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СУРГАЛТ”**

2026 оны 02 сарын 10-ны өдөр
ХАМРАХ ХҮРЭЭ: Жуулчны бааз болон
Тур операторын бизнес эрхлэгч нарт

**БАЙГУУЛЛАГЫН ОРЛОГЫН
МЕНЕЖМЕНТ, ҮНЭ БОДОЛТ**

2026 ОНЫ 02 САРЫН 11-НИЙ ӨДӨР 10:00 ЦАГТ
ЖББХСХ ЗОХИОН БАЙГУУЛЖ БАЙГАА ЭЭЛЖИТ
СУРГАЛТАНДАА ТА БҮХНИЙГ УРЬЖ БАЙНА



2.3.2. Болзошгүй гамшиг, ослын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, үйл ажиллагаандаа мөрдөгдөх хууль эрх зүй, стандарт, аюулгүй байдлын чиглэлээр мэдлэг олгох зорилгоор Аялал жуулчлалын мэргэжлийн холбооны Жуулчны бааз, байршуулах хэрэгслийн салбар холбоо, ОБЕГ-ын Гамшгаас хамгаалах сургалтын төвийн 116 дугаар ангитай хамтран “Гамшгаас урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангах нь” сэдэвт сургалтыг 2026 оны 02 дугаар сарын 12-ны өдөр зохион байгууллаа. Сургалтаар гамшигийн эрсдэлийн үнэлгээ хийх, урьдчилан сэргийлэх бэлэн байдлыг хангах, зарлан мэдээлэл, нүүлгэн шилжүүлэлт, гамшиг ослын үед анхан шатны тусламжийг хэрхэн шуурхай, үр дүнтэй хүргэх зэрэг сэдвүүдээр мэдээлэл өгч сургалтад байршуулах үйлчилгээний байгууллагуудын нийт 70 гаруй ажилтан, албан хаагч хамрагдлаа.



2.4. Гадаад орнуудад зохион байгуулагдах аялал жуулчлалын хурал, зөвлөгөөн, үзэсгэлэн, арга хэмжээнд аялал жуулчлалын болон жуулчлалын үйлчилгээний байгууллагуудыг хамруулах;

Монголд зочлох жил"-ийн хүрээнд Монгол Улс, Улаанбаатар хотыг гадаадад сурталчлах, Европын орнуудаас ирэх жуулчдын урсгалыг нэмэгдүүлэх зорилгоор ХБНГУ-ын Берлин хотноо 2026 оны 03 дугаар сарын 03-05-ны өдрүүдэд зохион байгуулагдсан 60 дахь удаагийн "ITB Berlin" олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд Аялал жуулчлалын мэргэжлийн холбооны Европын зах зээлийн салбар холбооны 9 тур оператор компани оролцож "Go Mongolia" үндэсний брэндийн хүрээнд үйл ажиллагаагаа сурталчилсан.

ГУРАВ. ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД:

3.1. Байгууллагын үйл ажиллагаа, бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилт, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийн чиглэлээр:

3.1.1. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчтай байгуулсан 2026 оны “Хариуцлагын гэрээ”-г 6 бүлэг 48 заалтаар, Байгууллагын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор батлагдсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”-ын хүрээнд 12 зорилтын 70 арга хэмжээг хэрэгжүүлэхээр боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

3.1.2. Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд, нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчтай төрийн зарим чиг үүргийг 2026 онд төлөөлөн гүйцэтгүүлэхээр байгуулах гэрээнд аялал жуулчлалын чиглэлээр хамтран хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг боловсруулан хүргүүлэн 16 арга хэмжээ батлагдаж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

3.2. Архив, албан хэрэг хөтлөлт, өргөдөл, гомдлын шийдвэрлэлт

3.2.1. Төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, аж ахуй нэгжүүдээс 2026 оны 1 дүгээр улирлын байдлаар ирүүлсэн хариутай 37 албан бичиг, хариугүй 73 албан бичиг нийт 110 албан бичгийг бүртгэж, 137 албан бичгийг албан хэрэг хөтлөлтийн заавар, журам, стандартын дагуу боловсруулан бусад байгууллагуудад илгээсэн. Албан бичгийн шийдвэрлэлт 100 хувийн үзүүлэлттэй байна.

3.2.2. “Монгол бичгээр үйлдэх баримт бичгийн хэвлэмэл хуудас түүний бүрдэлд тавих үндсэн шаардлага” MNS6395:2022 стандартын дагуу Нийслэлийн аялал жуулчлалын газрын даргын 33 тушаал, 137 албан бичгийг хос бичгээр хөтлөн явуулсан.

3.2.3. Нийслэлийн Аялал жуулчлалын газарт 2026 оны 1 дүгээр улирлын байдлаар нийт 7 өргөдөл гомдол, санал хүсэлт ирүүлснийг 100% эцэслэн шийдвэрлэж хуулийн хугацаанд хариу өгч ажилласан. Нийт өргөдөл, гомдлоос албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол болон саналын шинжтэй өргөдөл ирээгүй бөгөөд шийдвэрлэлтийн явцад хугацаа хэтэрч шийдвэрлэсэн өргөдөл, гомдол байхгүй. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 3 хоног 18 цаг 24 минут байна.

3.3. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх, авилга, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр:

3.3.1. Нийслэлийн Аялал жуулчлалын газрын албан хаагчдын 2026 оны сургалтын төлөвлөгөөний дагуу төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчдыг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 1, “Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах” сэдэвт сургалтад 10, “Цахим орчны боломж ашиглан ажлын бүтээмж нэмэгдүүлэх нь” сэдэвт сургалтад 1, Монгол бичгийн сургалтад 1, нийт 12 удаагийн сургалтад 25 албан хаагчийг хамруулсан.



3.3.2. Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомж, байгууллагын дотоод журмын дагуу 2 албан хаагчид ээлжийн амралтын цалин, давхардсан тоогоор 26 албан хаагчид илүү цаг ажилласан нэмэгдэл хөлс олгож, хүний нөөцийн нэгдсэн систем <https://hrm.csc.gov.mn/> системд албан хаагчдын бүрэлдэхүүн хөдөлгөөний мэдээллийг тогтмол шинэчлэн ажиллаж байна.

3.3.3. Албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулах ажлыг Хан-Уул дүүргийн эрүүл мэндийн төвтэй хамтран 15 албан хаагчийг урьдчилан сэргийлэх үзлэгт, Сөүл эмнэлэгтэй хамтран 3 албан хаагчийг багц шинжилгээнд хамрууллаа.

3.3.4. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу 8 албан хаагч хувийн ашиг сонирхол болон хөрөнгө орлогын мэдүүлгээ хугацаандаа тайлагнаж, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийн дүгнэлтийг үндэслэн 1 албан хаагчийг томилсон. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх 1 удаагийн сургалтад 3 албан хаагчийг хамруулсан.

3.4. Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын чиглэлээр:

3.4.1. Засгийн газрын 2022 оны 201 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журам"-ын хүрээнд 5 бүлгийн 87 үзүүлэлтийн мэдээллийг улирал бүр <http://www.frontoffice-dev.shilen.gov.mn/> цахим хуудсанд тогтсон хугацаанд байршуулж, 2026 оны I улирлын мэдээг хугацаанд нь илгээсэн.

ИТ	Бэлтгэл	МЭД	СЭТ	Төл
1	100	100	100	100
2	100	100	100	100
3	100	100	100	100
4	100	100	100	100
5	100	100	100	100

3.4.2. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан байнга ил тод, нээлттэй байлгах мэдээллүүд байгууллагын зорилго зорилт, үндсэн чиг үүрэг, бүтэц зохион байгуулалт, албан хаагчдын мэдээлэл, хаяг, утасны дугаар, төрийн үйлчилгээ, өргөдөл гомдлын шийдвэрлэлт болон хүний нөөц, санхүүгийн ил тод байдал, бодлогын баримт

бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, үйл ажиллагааны тайлан, мэдээ, мэдээллийг байгууллагын цахим хуудсанд тогтмол шинэчлэн ажиллаж байна.

**ДӨРӨВ. БУСАД ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД:**

4.1. Сар шинийн баярыг угтаж Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас санаачлан 2026 оны 02 сарын 10-15 ны өдрүүдэд зохион байгуулсан бүх нийтийн их цэвэрлэгээний ажилд оролцох уриалгыг Монголын Аялал жуулчлалын холбоо, Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо, “Өргөө” дэн буудал эрхлэгчдийн холбоо, Монголын зочид буудлын холбоо, Монголын рестораны, зоогийн газруудын холбоодуудад албан бичгээр хүргүүлж, мөн Нийслэлийн Аялал жуулчлалын газрын 16 албан хаагч батлагдсан хуваарийн дагуу С.Жамъяан Гүнгийн гудамжны гаднах орчны цэвэрлэгээг 2026 оны 02 сарын 13-ны өдрийн 09:30-11:30 цагийн хооронд зохион байгуулав.



ТАНИЛЦСАН:
ДАРГА

D. Batsukh

Д.БАТСҮХ

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА

D. Ganbold

Д.ГАНБОЛД

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:
БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ТАЙЛАН, ТОГТООЛ ШИЙДВЭР,
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТ ХАРИУЦСАН АХЛАХ
МЭРГЭЖИЛТЭН

O. Nyambat

О.НЯМБАТ